**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 10 өдөр          Дугаар А/573          Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөгч хөтөлбөр”- ийн 4 дүгээр зүйлийн 4.4, 4.10-т заасны дагуу Баруун бүсийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультан, ажилтнуудын сургалт зөвлөгөөн, урлаг спортын арга хэмжээг 2019 оны 9 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулах арга хэмжээний зардалд 24240,0 мянган төгрөг /Хорин дөрвөн сая хоёр зуун дөчин мянган/-ийг хавсралтаар баталж гүйцэтгэлээр зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 5.3 дахь заалтын зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          Б.ДҮГЭРЖАВ

Zax A/573 Ch
02 02807

Аймгийн Засаг даргын 2019 оны
9 дүгээр 07-ны өдрийн А/573 дугаар
захирамжийн хавсралт

БАРУУН БҮСИЙН НӨУБ-ЫН СОНГУУЛЬТАН, АЖИЛТНУУДЫН
УРЛАГ, СПОРТЫН НААДМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

мян.төгрөгөөр/

| д/д | Зардлын зүйл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж | Нэгжийн дүн | Нийт өртөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Буудлын зардал | хүн/өдөр | 60 | 2 | 36000 | 4320000 |
| 2 | Шагналын зардал | төрлөөр | 1 | 1 | 2200000 | 2200000 |
| 3 | Өргөмжлөл, медальны үнэ | ширхэг | 1 | 1 | 1845000 | 1845000 |
| 4 | Аймгуудад өгөх гарын бэлэг | багц | 4 | 1 | 150000 | 600000 |
| 5 | Аймгуудаас ирэх төлөөлөгчдөд өгөх гарын бэлэг | багц | 65 | 1 | 15000 | 975000 |
| 6 | Урлагийн тоглолт | өдрөөр | 2 | 1 | 1250000 | 2500000 |
| 7 | Хувцасны үнэ | иж бүрдэл | 50 | 1 | 80000 | 4000000 |
| 8 | Хоолны зардал | хүн/өдөр | 120 | 2 | 15000 | 1800000 |
| 9 | Хүлээн авалтын зардал | хүн/өдөр | 120 | 1 | 50000 | 6000000 |
| 10 | Сургалт, зөвлөгөөний зардал | хүн/өдөр | 110 | 100109 | 11012000 | 11012000 |
| | *Нийт дүн* | | | | | 35252000 |
| | Төлөөлөгч хөтөлбөрөөс | | | | | 24240000 |

-оОо-